Баянгол дүүргийн Засаг даргын тамгын
газрын 2022 оны 06 дугаар сарын 28өдрийн
01 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт
/1262

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН /ӨССӨН ДҮНГЭЭР/

2022 оны 06 дугаар сарын 25 Улаанбаатар хот

"Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем"–ийг ашиглан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлүүлэх, эргэн мэдээлэх үйл ажиллагааг Нийслэлийн Засаг даргын А/1086 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам"-ын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Баянгол дүүрэгт 2022 оны хагас жилийн байдлаар 3853 өргөдөл, гомдол ирсэн. Нийт 3853 өргөдлөөс шийдвэрлэсэн 3632 буюу 94,0%, шийдвэрлэх шатандаа 218 буюу 5,9%, хугацаа хэтэрч 3 өргөдөл буюу 0,1%-ийг эзэлж өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 16 цаг 17 минут байна.

Баянгол дүүрэгт 2022 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн хандалтын байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын хэлтсээс үйлчилгээ авах хүсэлтүүд нийт өргөдлийн 46%-ийг эзэлсэн.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал:



	Нийт	Шийдвэрлэж хариу өгсөн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Судалж байгаа
2022 оны 2 дугаар улирал	3853	3632	2	218

2022 оны 2 дугаар улиралд ирсэн нийт өргөдлийг төрлөөр нь авч үзвэл хүсэлт 1677 буюу 73%, гомдол 546 буюу 24%, талархал 55 буюу 2,%, санал 17 буюу 0,7%, мэдэгдэл 1 буюу 0,3%-ийг эзэлж байна.

Өргөдөл гомдлыг төрлөөр нь харьцуулсан үзүүлэлт:



	Хүсэлт	Гомдол	Талархал	Санал	Мэдэгдэл
2021 оны 2 дугаар улирал	1605	422	15	1	
2022 оны 2 дугаар улирал	1677	546	55	17	1

Өргөдөл гомдыг шийдвэрлэх явцад үүссэн зөрчлийг харьцуулсан үзүүлэлт:



	Нийт	Өдөрт нь багтаан хүлээж аваагүй зөрчил	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	Буцаалтыг 3 хоногт багтаан шилжүүлээгүй зөрчил	Файл хавсаргааг үй зөрчил
2021 оны 2 дугаар улирал	180	89	61	25	5	
2022 оны 2 дугаар улирал	358	172	38	98	49	1

Өргөдөл, гомдол шийдвэрлэх явцад хамгийн их зөрчил гаргасан хэлтсүүд:



	Нийгмийн даатгалын хэлтэс	Татварын хэлтэс	Цагдаагийн газар	Эрүүл мэндийн төв	Улсын бүртгэлийн хэлтэс
Зөрчлийн тоо	93	74	34	44	29

Дүүргийн хэмжээнд өргөдөл шийдвэрлэх явцад 358 зөрчил үүсч нийт зөрчлийн 76,5%-ийг Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн газар, Эрүүл

мэндийн төв, Улсын бүртгэлийн хэлтэс эзэлж хамгийн их зөрчлийг үүсгэсэн үзүүлэлттэй байна.

Дүүргийн дэх Цагдаагийн газар хугацаа хэтрүүлж 2 өргөдөл шийдвэрлэсэн.

Дүүргийн Засаг даргын Тамгын газарт иргэдээс 527 өргөдөл, гомдол ирсэн. Нийт 527 өргөдлөөс шийдвэрлэсэн 494 буюу 94%-ийг шийдвэрлэн шатандаа 33 буюу 7%-ийг судалж байна.

Нийт өргөдлийг төрлөөр нь авч үзвэл хүсэлт 349 буюу 66%, гомдол 166 буюу 31%, таархал 1 буюу 0,1%. санал 11 буюу 2%-ийг эзэлж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 16 цаг 16 минут буюу индексийн үнэлгээ 0,855 "А" үнэлгээгээр дүгнэгдсэн.

Өргөдөл гомдлыг төрлөөр нь харьцуулсан үзүүлэлт:



	Хүсэлт	Гомдол	Таархал	Санал	Мэдэгдэл
2021 оны 2 дугаар улирал	550	95		1	
2022 оны 2 дугаар улирал	349	166	1	11	

Тайлант хугацаанд өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчил гаргаагүй болно. Өргөдөл шийдвэрлэх явцад 26 зөрчил үүсч, гарсан зөрчлийн хэмжээг өмнөх оны тайлант үетэй харьцуулбал 57,3%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Өргөдөл гомдыг шийдвэрлэх явцад үүссэн зөрчлийг харьцуулсан үзүүлэлт:



	Нийт	Өдөрт нь багтаан хүлээж аваагүй зөрчил	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	Буцаалтыг 3 хоногт багтаан шилжүүлээгүй зөрчил
2021 оны 2 дугаар улирал	61	19	33	6	3
2022 оны 2 дугаар улирал	26	13	6	7	

2022 оны 2 дугаар улиралд саналын шинжтэй 11 өргөдөл ирүүлсэн. Саналын шинжтэй өргөдлийг хандалтаар нь авч үзвэл:



Саналын шинжтэй өргөдөлд дүн шинжилгээ хийж батлагдсан хүснэгтийн дагуу тайланг гаргаж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.

Иргэдээс ирүүлсэн гомдлын шинжтэй өргөдөлд дүн шинжилгээ хийж үзэхэд Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэстэй холбоотой асуудал нийт гомдлын 41%-ийг эзэлж байна. Гомдлын шинжтэй өргөдлийг хандалтаар нь авч үзвэл СӨХ-той асуудал-14%, нийтийн эзэмшлийн гудамж зам талбай болон явган хүний зам засуулах, хийлгэх асуудлаар хамгийн их буюу нийт гомдлын 44%-ийг эзэлж байна.



Иймд чиглэлийн дагуу Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс нь “Иргэдээс ирүүлсэн хандалт өндөр өргөдөл, гомдлын гомдлыг бууруулах чиглэлээр хийх ажлын тусгай төлөвлөгөө” боловсруулж биелэлтийг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.

Дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2022 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн хандалтын байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд нийт өргөдлийн 31%-ийг

СӨХ-ны үйл ажиллагаа, хог цэвэрлэгээ, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн тохижилт болон эмчилгээний мөнгөн тусламжийн асуудлаар хамгийн их хандсан байх тул дараах ажлыг зохион байгуулсан.

Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг сайжруулах, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэд, оршин суугчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын тоог бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

1.Баянгол дүүргийн Засаг дарга, Монголын Сууц өмчлөгчдийн холбооны Дээд зөвлөлийн Баянгол дүүрэг дэх Салбар зөвлөл, Баянгол дүүргийн Сууц өмчлөгчдийн холбооны Нэгдсэн зөвлөл нар хамтран дүүргийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэх арга хэмжээг харилцан зөвшилцөж, хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд СӨХ-ны үйл ажиллагааг шилэн, ил тод, нээлттэй болгох ажлыг хэрэгжүүлж байна.

Шинээр байгуулагдсан болон дахин зохион байгуулалтад орсон СӨХ-үүд арилжааны банкнуудтай харилцах данс нээлгэх, гүйцэтгэх захирал томилогдсон баталгаажуулалтыг тухай бүр тогтмол хийж хэрэгжүүлж байна. Дүүргийн хэмжээнд 267 СӨХ үйл ажиллагаа явуулж байгаагаасс "Шилэн" СӨХ-ны сургалтад 200 СӨХ буюу 74,9 хувь хамрагдаж, шилэн системийг нэвтрүүлж Skypro ХХК-ний "АЙЛ" программыг ашиглахаар 90 СӨХ гэрээ байгуулсан байна. Цаашид "Шилэн СӨХ" программыг бүх СӨХ-д нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Баянгол дүүргийн хэмжээнд 50 СӨХ шилэн сөх системийг ашиглахаар гэрээ байгуулан мэдээллийн бааз үүсгэж ажилласан. Баянгол дүүргийн 12 дугаар хорооны 5 СӨХ, 13 дугаар хорооны 2 СӨХ, 14 дүгээр хорооны 3 СӨХ, 15 дугаар хорооны 4 СӨХ-үүдийн нутаг дэвсгэр дэх сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд хяналт хийх үзлэгийг 2022 оны 03 дугаар сарын 28-ний өдрөөс эхлэн 9 хоног шалгалт хийж холбогдох хууль журмын хүрээнд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2. Хог хаягдлын шинэчилсэн найруулга болон холбогдох хууль тогтоомжийг иргэдэд таниулах сурталчлах зорилгоор үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад мэдэгдэх хуудас хүргэж олон нийтийн байцаагч болон хэсгийн ахлагч, зохион байгуулагч нараар ухуулан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа хог хаягдлын ангилан ялгах савгүй 120 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шаардлага тавьснаас 44 байгууллага зориулалтын хогийн сав байршуулсан бөгөөд зориулалтын хогийн савыг 36%-р нэмэгдүүлсэн.

3. Баянгол дүүрэг 2022 онд иргэд, оршин суугчынхаа ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэх зорилгоор дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт (ДТХО)-аар хэд хэдэн байршилд нийт 9383.14м2 явган хүний замыг шинээр тавьж, засварлахаар төлөвлөсөн.

Дээрх ажлын хүрээнд 2022 оны хагас жилийн байдлаар 2595.4м2 явган хүний зам хийгээд байна. Үүнд:

БГД, 1-р хороо, 178 дугаар цэцэрлэг урд

БГД, 1-р хороо, Улаанбаатар Төмөр зам, Нэгдүгээр цэцэрлэгийн урд хэсэг

БГД, 2-р хороо, Төмөр замын бүжгийн чуулгын зүүн талаас 6 дугаар байр хүртэл

БГД, 2-р хороо, Ган зам паласын зүүн талаас 26-р байр хүртэл

БГД, 2-р хороо, 7/3 байрны зүүн талаас Баруун 4 зам хүртэл

БГД, 3-р хороо, 50-р байрны зүүн урд талын уулзвараас хойш 69 дүгээр байрны зүүн талын уулзвар хүртэлх

БГД, 13-р хороо, Хасбаатарын гудамж 9 дүгээр байрны урд буюу 77 дугаар цэцэрлэгийн баруун хойд үзүүрээс 1 дүгээр байрны ард талын шат хүртэл

Мөн дүүргийн 25 дугаар хороо "Голден парк" хотхоны автобусны буудлын урд хэсэгт 382м2 явган хүний зам тавихаар талбайн бэлтгэл ажлыг хангаад байна.

Дүүргийн 2, 9, 10, 11, 16, 20, 21, 22, 23 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 42км шороон зам хусах, тэгшлэх ажлыг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 21 дүгээр хорооноос

эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар 9, 10, 21 дүгээр хорооны ажил дуусаж, 22 дугаар хороон дээр ажил үргэлжилж байгаа бөгөөд ажлын явц 60 хувьтай үргэлжилж байна.

4. Зорилтот бүлгийн иргэдийн гаргасан өргөдөл, хүсэлтийг судалж үзээд зорилтот бүлгийн 600 өрхөд хүнсний багц, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалыг тус тус үндэслэн 26 иргэнд нэг удаагийн эмчилгээний буцалтгүй тусламж, Дүүргийн засаг даргын нөөц хөрөнгөөс 10 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсэн.

5. Дүүргийн Засаг даргын 2022 оны 09/324 дугаар албан бичгээр (Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай) Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт уламжилсан

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулахын тулд дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

1. Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг баримтлан өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бодитой шийдвэрлэж ажиллахыг харьяа хэлтэс, албадад үүрэг болгон шийдвэрлэлтэд хяналт тавин өдөр тутам арга зүйн зөвлөгөө өгч байна.

2. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавин, иргэдээс ирүүлж байгаа өргөдөлд дүн шинжилгээ хийж улирал бүр www.bgd.mn цахим хуудсанд байршуулж байна.

3. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах тусгай төлөвлөгөө боловсруулан нэгжийн даргаар батлуулж үйл ажиллагаандаа тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4. Иргэдээс ирүүлсэн хандалт өндөр өргөдөл, гомдлын гомдлыг бууруулах чиглэлээр хийх ажлын тусгай төлөвлөгөө" боловсруулж биелэлтийг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.

5. Иргэдээс ирүүлсэн саналын шинжтэй өргөдөлд дүн шинжилгээ хийж байгууллагын үйл ажиллагаанд тусгаж хэрэгжүүлсэн тухай тайлан гаргаж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.

6. Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй чанартай хүргэх, мэдээ, мэдээллээр хангах, өргөдөл гомдол, санал хүсэлтийг түргэн шуурхай хүлээн авах зорилгоор 1800-1222 тусгай дугаарыг ажиллуулж иргэдэд эрх зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх, эрүүл мэнд, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжтой холбоотой асуудлаар, мөн нийгмийн халамжийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байна.

7. Өргөдөл гомдлын шийдвэрлэх үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж өргөдөл шийдвэрлэх хугацаа болон зөрчлийн үзүүлэлтийг бууруулан ажилтан албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж ажиллах тухай зөвлөмжийг (25 хороо, 14 харьяа хэлтэс алба)-д Тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн 01/157, 01/158 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан.

8. 2022 оны 1 дүгээр улирлын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж хамгийн их зөрчил гаргаж, хугацаа хэтрүүлж ажилласан харьяа хэлтсүүдэд "Зөрчил арилгуулах тухай" Тамгын газрын даргын 2022 оны 01/569, 01/570, 01/571, 01/572, 01/573 дугаар албан бичиг хүргүүлсэн.

Удаа дараа зөрчил гаргаж, ажлын хариуцлага алдсан албан хаагчдад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хариуцлага тооцуулан, авсан арга хэмжээг нэгтгэсэн.

9. "Иргэдээс нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх нэгдсэн систем ба түүний хэрэглээ" сэдэвт сургалт зохион байгууллаа.

Сургалтад Дүүргийн 25 хорооны ажлын албаны дарга, зохион байгуулагч нар оролцож, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг холбогдох хууль журмын хүрээнд үр дүнтэй зохион

байгуулах, өргөдөл гомдлыг системийн ашиглалтыг сайжруулах, зөрчлийн үзүүлэлтийг бууруулан ажиллах талаар мэдээлэл өгсөн.



10. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд түргэн шуурхай, чанартай үйлчлэх зорилгоор өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үнэлгээг албан хаагч тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд тусган хяналт тавин ажиллаж байна.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.МӨНГӨНХУЯГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ГЭРЭЛЭЭ

Баянгол дүүргийн Засаг даргын тамгы
газрын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрий
01/1262 дугаар албан бичгийн дөрөвдүгээр хавсрал

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ
ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 25

Улаанбаатар хо

№	Хийгдэх ажил	Биелэлт	Хугацаа	Тайлбар
1	2022 оны 1 дүгээр улиралд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам болон өргөдөл гомдлын програм ашиглалтын талаар сургалт зохион байгуулах;	2022 оны "Иргэдээс нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх нэгдсэн систем ба түүний хэрэглээ" сэдэвт сургалт зохион байгуулаа. Сургалтад Дүүргийн 25 хорооны ажлын албаны дарга, зохион байгуулагч нар оролцож, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг холбогдох хууль журмын хүрээнд үр дүнтэй зохион байгуулах, өргөдөл гомдлыг системийн ашиглалтыг сайжруулах, зөрчлийн үзүүлэлтийг бууруулан ажиллах талаар мэдээлэл өгсөн.	1 дүгээр улирал	
2	Иргэдээс ирүүлж байгаа саналын шинжтэй өргөдлийг удирдлагад танилцуулж, холбогдох хэлтсийн төлөвлөгөөнд тусгаж, тайланг нэгтгэх;	2022 оны 2 дугаар улиралд ирүүлсэн саналын шинжтэй 11 өргөдөл ирсэн. Иргэдээс ирсэн саналын шинжтэй өргөдөлд дүн шинжилгээ хийж үзэхэд нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний зам талбайг тохижуулах болон засварлуулах асуудал 63%-ийг эзэлж байна. Саналын шинжтэй өргөдлийг холбогдох мэргэжилтэнд шилжүүлж шийдвэрлэлтэд хяналт тавьж биелэлтийг нэгтгэж НЗДТГ-т хүргүүлсэн.	Сар, улирал бүр	
3	Иргэдээс гаргаж байгаа өргөдөл, гомдлын шалтгаан нөхцлийг судалж, өргөдлийн хандалтыг бууруулах чиглэлээр холбогдох хэлтсийн төлөвлөгөөнд тусгаж биелэлтийг нэгтгэх;	Иргэдээс ирүүлсэн хандалт өндөр өргөдөл, гомдлын гомдлыг бууруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан батлууж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын төрлийн тайланд дүн шинжилгээ хийж үзэхэд нийт өргөдлийн 32%-ийг гомдлын шинжтэй өргөдөл эзэлж байна. Нийт ирсэн гомдлын шинжтэй	Улирал бүр	

		өргөдөлд дүн шинжилгээ хийж үзэхэд 74%-нь Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэст хандсан. Гомдлын шинжтэй өргөдлийн хандалтын байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд СӨХ-ын үйл ажиллагаатай холбоотой асуудал-41%, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт болон явган хүний зам хийлгэх, засварлуулах асуудлаар 37%-ийг эзэлж байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын гомдлын шинжтэй өргөдлийг бууруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг нэгтгэж НЗДТГ-т хүргүүлсэн. Иргэдээс ирүүлсэн хандалт өндөр өргөдөл, гомдлын гомдлыг бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж НЗДТГ-т хүргүүлсэн.		
4	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдалд өдөр тутам хяналт тавьж, сар улирал бүр зөрчлийн тайлан гаргаж удирдлагад танилцуулах;	Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг баримтлан өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бодитой шийдвэрлэж ажиллахыг харьяа хэлтэс, албадад үүрэг болгон шийдвэрлэлтэд хяналт тавин өдөр тутам арга зүйн зөвлөгөө өгч байна. Баянгол дүүрэгт 2022 оны 2 дугаар улиралд нийт 2296 өргөдөл, гомдол ирсэн. Нийт 2296 өргөдлөөс шийдвэрлэсэн 2076 буюу 90,0%, шийдвэрлэх шатандаа 218 буюу 9,5%, хугацаа хэтэрч 2 өргөдөл буюу 0,5%-ийг эзэлж өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 16 цаг 17 минут байна. Нийт өргөдлийг төрлөөр нь авч үзвэл хүсэлт 1677 буюу 73%, гомдол 546 буюу 24%, талархал 55 буюу 2,%, санал 17 буюу 0,7%, мэдэгдэл 1 буюу 0,3%-ийг эзэлж байна. Баянгол дүүрэгт өргөдөл, гомдол шийдвэрлэх явцад өдөрт нь багтааж шилжүүлээгүй зөрчил 38, буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил 49, өдөрт нь багтаан хүлээж аваагүй зөрчил 172, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо 98, холбогдох файл хавсаргаагүй зөрчил 1 буюу нийт 325 зөрчил үүсч 2021 оны мөн үеийн тайлантай харьцуулбал 55% өссөн үзүүлэлттэй байна.	Сар, улирал бүр	

		Дүүргийн Цагдаагийн газар нь өргөдөл шийдвэрлэх явцад 2 өргөдлийг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газарт иргэдээс 527 өргөдөл, гомдол ирсэн. Нийт 527 өргөдлөөс шийдвэрлэсэн 494 буюу 94%-ийг шийдвэрлэн шатандаа 33 буюу 7%-ийг судалж байна. Нийт өргөдлийг төрлөөр нь авч үзвэл хүсэлт 349 буюу 66%, гомдол 166 буюу 31%, талархал 1 буюу 0,1%. санал 11 буюу 2%-ийг эзэлж байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 16 цаг 16 минут буюу индексийн үнэлгээ 0,855 "А" үнэлгээгээр дүгнэгдсэн. Засаг даргын Тамгын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх явцад өдөрт нь багтааж шилжүүлээгүй 6, өдөрт багтааж хүлээж аваагүй 13, явцын тэмдэглэл хөтлөөгүй 7 зөрчил буюу нийт 26 зөрчил үүссэн. Тайлант хугацаанд өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчил гаргаагүй болно. Өргөдөл шийдвэрлэх явцад 26 зөрчил үүсч, гарсан зөрчлийн хэмжээг өмнөх оны тайлант үетэй харьцуулбал 57,3%-иар буурсан үзүүлэлттэй байна. 1. Иргэдээс гаргасан өргөдлийн иргэний хандалтын тайланд дүн шинжилгээ хийж үзэхэд 22 иргэн хоёроос дээш удаа хандсан байна. Тайланг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлэж ажиллахыг анхааруулж, тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2. Иргэдээс гаргасан саналын шинжтэй өргөдөлд дүн шинжилгээ хийж үзэхэд 11 иргэн саналын шинжтэй өргөдөл ирүүлсэн байна. Саналын шинжтэй өргөдлийг холбогдох хууль журмын хүрээнд судалж шийдвэрлэсэн тухай тайланг хэлтсүүдээс авч нэгтгэн НЗДТГ-т хүргүүлсэн 3. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайланг гаргаж НЗДТГ-т хүргүүлсэн.		

		Мэргэжилтнүүдийн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, өдөр тутам арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.		
5	Иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэхгүй, өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг биелүүлэхгүй зөрчил гаргаж ажиллаж байгаа албан албан хаагчид хариуцлага тооцон мэдэгдэл, албан шаардлага хүргүүлж үр дүнг тооцон ажиллах;	Өргөдөл гомдлын шийдвэрлэх үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж өргөдөл шийдвэрлэх хугацаа болон зөрчлийн үзүүлэлтийг бууруулан ажилтан албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж ажиллах тухай зөвлөмжийг (25 хороо, 14 хэлтэс алба)-д Тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/157, 01/158 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан. 2022 оны 1 дүгээр улирлын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн байдалд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд нийгмийн даатгалын хэлтэс-73, татварын хэлтэс-58, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс хугацаа хэтрүүлж -2, Улсын бүртгэлийн хэлтэс-8, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс-11 зөрчил үүсгэн дүүргийн хэмжээнд хамгийн их зөрчил гаргасан. Иймд Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/569, 01/570, 01/571, 01/572, 01/573 дугаар албан бичгээр зөрчил гаргасан албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж ажиллах тухай албан шаардлага хүргүүлж, ажлын хариуцлага алдсан алба хаагчдад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хариуцлага тооцуулан ажилласан. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд түргэн шуурхай, чанартай үйлчлэх зорилгоор өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үнэлгээг албан хаагч тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд тусган хяналт тавин ажиллаж байна.	Сар, улирал бүр	
6	Иргэдээс ирүүлж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланд дүн шинжилгээ хийж сар улирал бүр www.bgd.mn цахим хуудсанд байршуулан иргэдийг мэдээ, мэдээллээр тогтмол ханган ажиллах;	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавин, иргэдээс ирүүлж байгаа өргөдөлд дүн шинжилгээ хийж сар, улирал бүр www.bgd.mn цахим хуудсанд байршуулж байна.	Сар, улирал бүр	

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.МӨНГӨНХУЯГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ГЭРЭЛЭЭ

Баянгол дүүргийн Засаг даргын тамгын
газрын 2022 оны 06 дугаар сарын 26-өдрийн
01/1262 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС ГАРГАСАН САНАЛЫН ШИНЖТЭЙ
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 25 Улаанбаатар хот

2022 оны 2 дугаар улиралд ирүүлсэн саналын шинжтэй өргөдөлд дүн шинжилгээ хийж үзэхэд нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний зам талбайг тохижуулах болон засварлуулах асуудал 63%-ийг эзэлж байна. Иргэдээс ирсэн саналын шинжтэй өргөдлийг тухай бүр шийдвэрлэж холбогдох хууль, журмын хүрээнд хариу хүргүүлсэн.

№	Санал ирсэн эх үүсвэр	Саналыг үйл ажиллагаандаа тусгах боломжтой эсэх	Иргэний санал	Шийдвэрлэлт
1	11-11 төв	Боломжтой	4 дүгээр хороо Төмөр замын хороолол орчмын байрнуудын өнгө үзэмж бараан байна. Холбогдох байгууллагад уламжлуулах тухай	Барилга хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвд мэдэгдсэн болно.
2	11-11 төв	Боломжтой	1 дүгээр хороо, Богд ар хорооллын 7 дугаар байрны арын замыг дулааны шугам хоолой засварлан гээд замыг эвдэж, шороо овоолж орхиод явсан тухай	1 дүгээр хороо, Богд ар хорооллын 7 дугаар байрны арын замыг дулааны шугам хоолой засварлах ажлаар замыг эвдэж, барилгын хог хаягдлыг үлдээгээд явсан асуудлыг чиг үүргийн дагуу Нийслэлийн Замын хөгжлийн газар хариуцаж ажилладаг тухай иргэнд утсаар мэдээлэл өгч ажиллалаа.

3	11-11 төв	Боломжтой	Дүүргийн 3 дугаар хорооны 51, 69 дүгээр байрны дундах гарааш буулгаж тохижилтын ажил хийлгэх тухай	Баянгол дүүргийн 3 дугаар хороо, 51,69 дүгээр байрны дунд байрлах гараашийг буулгаж тохижилт, ногоон байгууламж хийхээр Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-д санал явуулсан талаар иргэнд утсаар мэдээлэл өгч ажиллалаа.
4	Гар утасны аппликейшн	Боломжтой	Баянгол дүүргийн 18 дугаар хороо 88 дугаар цэцэрлэгийн хойно буюу 43 дугаар байрны баруун урд талд байрлах явган замын тохижилтын асуудлаар	Иргэний гаргасан хүсэлтийн дагуу байршил дээр нь ажиллаж, гүйцэтгэгч компани болох "Борхойн зам" ХХК-аар 2022 оны 05 дугаар сарын 25-31-ны хооронд засвар шинэчлэлийг хийлгэхээр шийдвэрлэв.
5	11-11 төв	Боломжтой	Өргөө кино театрын урд явган хүний зам хаагаад тавьсан саадыг цэгцэлмээр байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх тухай	Иргэний гаргасан хүсэлтийг Дүүргийн Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 05/991 дугаар албан бичгээр Дүүргийн ГЗБА-д уламжилсан.
6	11-11 төв	Боломжтой	Дүүргийн 2 дугаар хорооноос 3, 4 дүгээр хороолол руу өгсдөг зам дагуу байдаг далангийн хэсгийг тохижилтыг нь үргэлжлүүлж хийлгэх тухай	2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Иргэдэд зориулсан ногоон орчин, тохижилт" 2,6 дугаар хорооны далангийн тохижилтын ажлын төсөл арга хэмжээ батлагдаж, гүйцэтгэгч байгууллагаар "Diamondlux" ХХК шалгарч зураг төсвийн ажлыг эхлүүлээд байна.
7	11-11 төв	Боломжтой	Сургууль, цэцэрлэгийн спортын талбайг нь ашиглаад дасгал хөдөлгөөн хийх, иргэд чөлөөтэй амрах боломжийг бүрдүүлэх тухай	Нийслэлийн Засаг даргын 2022.06.03-ний өдрийн “Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд хөгжих, тоглох эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/763 дугаар захирамж батлагдсан бөгөөд захирамжийг сургууль, цэцэрлэгт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн сургууль, цэцэрлэгүүдээс аюулгүй байдлын зөвлөмж, анхааруулга байршуулж, 06:00-

				22:00 цагийн хооронд иргэд, олон нийтэд талбайгаа нээлттэй ашиглуулж байна.
8	11-11 төв	Боломжгүй	Төрийн байгууллагууд нь уялдаа холбоотой ажиллаж цахим системд анхаарах тухай.	Уг асуудлын хүрээнд "Баянгол дүүрэг дэх Нийгмийн даатгалын газарт www.e-mongolia.mn цахим системээр үйлчилгээ авч буй иргэдийн мэдээ мэдээлэлд түргэн шуурхай хяналт тавьж, эрүүл мэндийн болон бусад даатгалын цахим төлбөрийн баталгаажилтыг цаг тухай бүрд хийж ажиллах" тухай мэдэгдсэн бөгөөд дээрх асуудлын хүрээнд Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газраас цахим үйлчилгээ үзүүлэх боломжгүй тул Баянгол дүүргийн "Нэг цонхны үйлчилгээний цэгт Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээг үзүүлдэг болох" тухай шат дараатай хэлэлцэж байна.
9	11-11 төв	Боломжгүй	Баянгол дүүргийн Төрийн захиргааны байгууллагуудын албан хаагчид нь захиргааны байранд багтахгүй, Харьяа хэлтэс газрууд нь иргэд олохоргүй байршилд байгаа тул Төр захиргааны байруудыг нэг дор байршуулах тухай.	Тус дүүргийн төрийн захиргааны 1, 2 дугаар байранд Тамгын газар, Дүүргийн Харьяа байгууллагууд болон босоо удирдлагатай хэлтсүүдийн нийт 300 гаруй албан хаагчтай бөгөөд Баянгол дүүргийн Төрийн захиргааны байгууллагуудыг нэг дор байршуулах боломжгүй тул тухайн байгууллагуудын гадна хаягжилтыг сайжруулж, Дүүргийн угтах үйлчилгээ болон Иргэдэд үйлчлэх төвийн 1800-1222 дугаарын утсаар холбогдох мэдээ мэдээллийг цаг тухай бүрд өгч байна.
10	11-11 төв	Боломжтой	Дүүргийн 10 дугаар хороллын автобусны буудал дагуу байрлах түргэн үйлчилгээний цэгүүд явган хүний гарц хааж байрласан, орчин бохирдуулж, хүнсний бэлэн бүтээгдэхүүн	Иргэний гомдлын дагуу дүүргийн 5 дугаар хороонд байрлах 48 ТҮЦ-нд Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх талаар авах зарчим арга хэмжээний тухай" А/596 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн иргэдийн

			борлуулж байгаа талаар хандсан.	төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын” 5.2.3 Улирлын чанартай худалдаа, үйлчилгээ, ТҮЦ-д тавигдах шаардлагыг хүргүүллээ.
11	11-11 төв		Баянгол дүүргийн 11 дүгээр Баруун тасганы 2 дугаар гудамжинд явган хүний зам талбайтай болмоор байна. Барилгын ажил хийгдсэнээс болоод тухайн газрын зам эвдэрсэн. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх тухай	Судалж байна

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.МӨНГӨНХУЯГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ГЭРЭЛЭЭ

Баянгол дүүргийн Засаг даргын тамгы
газрын 2022 оны 06 дугаар сарын 28 өдрий
01/1262 дугаар албан бичгийн гуравдугаар хавсрал

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ГОМДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 25 Улаанбаатар хо

Д/Д	Хийгдэх ажил	Биелэлт	Хугацаа	Үр дүн	Тайлбар
1.	СӨХ-ны үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээллэх зорилгоор "Шилэн СӨХ" системийг нэвтрүүлж хариуцлагын тогтолцоог сайжруулна.	Дүүргийн хэмжээнд 267 СӨХ үйл ажиллагаа явуулж байгаас "Шилэн" СӨХ-ийн сургалтад 200 СӨХ буюу 74,9 хувь хамрагдаж, шилэн системийг нэвтрүүлж Skypro ХХК-ний "АЙЛ" программыг ашиглахаар 90 СӨХ гэрээ байгуулсан байна. Цаашид "Шилэн СӨХ" программыг бүх СӨХ-д нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	I-IV улиралд	Баянгол дүүргийн хэмжээнд 50 СӨХ шилэн сөх системийг ашиглахаар гэрээ байгуулан мэдээллийн бааз үүсгэж ажилласан. СӨХ-той асуудлаар ирүүлсэн өргөдлийн 2022 оны 1 дүгээр улирлын мөн үетэй харьцуулж үзэхэд 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
2.	Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлтэй хамтран сууц өмчлөгчдийн холбоодод түвшин тогтоох үзлэг шалгалт зохион байгуулна.	Баянгол дүүргийн 12 дугаар хорооны 5 СӨХ, 13 дугаар хорооны 2 СӨХ, 14 дүгээр хорооны 3 СӨХ, 15 дугаар хорооны 4 СӨХ-үүдийн нутаг дэвсгэр дэх сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд хяналт хийх үзлэгийг 2022 оны 03 дугаар	I-IV улиралд	Бүх СӨХ-д үзлэг шалгалт хийх бэлтгэл ажил хангагдсан. 14 СӨХ ны үйл ажиллагаанд хянал шалгалт хийж холбогдох хууль	

		сарын 28-ний өдрөөс эхлэн 9 хоног шалгалт хийсэн.		журмын хүрээнд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
3	Дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодыг шинээр бүртгэж гэрчилгээ олгох, бүртгэлээс байруудыг нэмж, хасах, бүртгэлд зохих өөрчлөлт хийх ажлыг эрчимжүүлнэ.	2022 оны 05 дугаар 09-ний өдрийн Дүүргийн Засаг даргын А/177 дугаар захирамжаар 6 сууц өмчлөгчдийн холбоодыг шинээр бүртгэж гэрчилгээ олгосон, 2 байрыг СӨХ-ийн бүртгэлд нэмж, 16 байрыг бүртгэлээс хассан, СӨХ-ийн гүйцэтгэх захирлыг томилсон баталгаажуулах бүртгэл хийх зэрэг зохих өөрчлөлтийн хийх ажлыг СӨХ болон иргэдээс хүсэлт холбогдох материалыг үндэслэн баталгаажуулж байна.	I-IV улиралд	Шинээр байгуулагдсан болон дахин зохион байгуулалтад орсон СӨХ-үүд арилжааны банкнуудтай харилцах данс нээлгэх, гүйцэтгэх захирал томилогдсон баталгаажуулалтыг тухай бүр тогтмол хийж хэрэгжүүлж байна.	
4.	Хог ангилан ялган хогийн сав байршуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа хог хаягдлын ангилан ялгах савгүй 120 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад шаардлага тавьсанаас 44 байгууллага зориулалтын хогийн сав байршуулсан бөгөөд зориулалтын хогийн савыг 36%-иар нэмэгдүүлсэн.	I-IV улиралд	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагууд зориулалтын хогийн сав байршуулснаар дүүргийн өнгө үзэмж сайжирч байна.	
5.	Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон хог хаягдлын чиглэлээр батлагдсан журам дүрмийг таниулан сурталчлахад чиглэсэн ажил зохион байгуулна.	Хог хаягдлын шинэчилсэн найруулга болон холбогдох хууль тогтоомжийг иргэдэд таниулах сурталчлах зорилгоор үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудад мэдэгдэх хуудас хүргэж Олон нийтийн байцаагч болон хэсгийн ахлагч, зохион байгуулагч нараар ухуулан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	I-IV улиралд	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд хог хаягдлын тухай хууль, зөрчлийн тухай хуулийн мэдлэгийг дээшлүүлэх сурталчлах, хог хаягдлыг ангилах ялгах системд үе шаттайгаар оруулан хяналт тавин ажиллаж байна.	

6	Нийтийн эзэмшлийн зам талбай болон явган хүний зам талбайн засвар шинэчлэлтийн ажлыг зохион байгуулж ажиллана	Баянгол дүүрэг 2022 онд иргэд, оршин суугчдынхаа ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэх зорилгоор дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт (ДТХО)-аар хэд хэдэн байршилд нийт 9383.14м2 явган хүний замыг шинээр тавьж, засварлахаар төлөвлөсөн. Дээрх ажлын хүрээнд 2022 оны хагас жилийн байдлаар 2595.4м2 явган хүний зам хийгээд байна. Үүнд: БГД, 1-р хороо, 178 дугаар цэцэрлэг урд БГД, 1-р хороо, Улаанбаатар Төмөр зам, Нэгдүгээр цэцэрлэгийн урд хэсэг БГД, 2-р хороо, Төмөр замын бүжгийн чуулгын зүүн хойд өнцгөөс 6 дугаар байр хүртэл БГД, 2-р хороо, Ган зам паласын зүүн талаас 26-р байр хүртэл БГД, 2-р хороо, 7/3 байрны зүүн талаас Баруун 4 зам хүртэл БГД, 3-р хороо, 50-р байрны зүүн урд талын уулзвараас хойш 69 дүгээр байрны зүүн талын уулзвар хүртэлх БГД, 13-р хороо, Хасбаатарын гудамж 9 дүгээр байрны урд буюу 77 дугаар цэцэрлэгийн баруун хойд үзүүрээс 1 дүгээр байрны ард талын шат хүртэл Мөн дүүргийн 25 дугаар хороо "Голден парк" хотхоны автобусны буудлын урд хэсэгт 382м2 явган		Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар шинэчлэлтийн ажлыг хийж хэрэгжүүлснээр иргэд аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэж байна.	

		хүний зам тавихаар талбайн бэлтгэл ажлыг хангаад байна. Дүүргийн 2, 9, 10, 11, 16, 20, 21, 22, 23 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 42км шороон зам хусах, тэгшлэх ажлыг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 21 дүгээр хорооноос эхлүүлсэн. Өнөөдрийн байдлаар 9, 10, 21 дүгээр хорооны ажил дуусаж, 22 дугаар хороон дээр ажил үргэлжилж байгаа бөгөөд 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Ажлын явц 60 хувьтай үргэлжилж байна.			

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.МӨНГӨНХУЯГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Д.ГЭРЭЛЭЭ